



## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БУА-2022/116/НА-СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Булган аймаг 2022 он</p>	<p>Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр Утас: 70342580 Цахим хаяг: <a href="mailto:ankhbayard@audit.gov.mn">ankhbayard@audit.gov.mn</a></p> <p>Аудитын менежер: Ж.Энхцоодол Утас: 70342716 Цахим хаяг: <a href="mailto:enhtsoodolj@audit.gov.mn">enhtsoodolj@audit.gov.mn</a></p> <p>Аудитор: Б.Пүрэвсүрэн Утас: 70353717 Цахим хаяг: <a href="mailto:dalaivan.orkhon@gmail.mn">dalaivan.orkhon@gmail.mn</a></p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

---

1. Аудитын санал дүгнэлт .....	2-3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
3. Аудитын тайлан .....	9
3.1 Ерөнхий зүйл .....	9
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	10
3.4 Материаллаг байдал .....	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга .....	11
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	11
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	12
3.8 Аудитын гол асуудал .....	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	13
4. Аудитын илрүүлэлт.....	13
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	15

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ХАА	Хөдөө аж ахуй

## АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ



### БУЛГАН АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхлагчдын өргөн чөлөө 1-120,  
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082  
Утас/Факс: 7034-3259  
E-mail: bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 47

танай \_\_\_\_\_ ны № \_\_\_\_\_ т

ЗЭД ХАНТАЙ БҮТЭЭЛИЙН  
НУРУУНЫ ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН  
ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГААНЫ  
ДАРГА Д.БОЛОРЧУЛУУН ТАНАА

### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

D:\bichighereg\2022A4\toot

• 006020038

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>137,369,220.09</u></b>	<b><u>131,803,715.45</u></b>
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	137,369,220.09	131,803,715.45
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	3,635,070.00	1,812,420.00
35110	Тусгай зориулалттай материал	3,635,070.00	1,812,420.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	130,234,150.09	126,491,295.45
35410	Бичиг хэргийн материал	1,787,546.00	1,010,966.02
35420	Аж ахуйн материал	31,500.00	2,512,000.00
35440	Түлш, шатах тослох материал	2,344,565.04	3,291,341.06
35470	Бусад хангамжийн материал	126,070,539.05	119,676,988.37
35600	Мал амьтад	3,500,000.00	3,500,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>719,419,033.09</u></b>	<b><u>758,601,095.39</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	719,419,033.09	758,601,095.39
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	712,519,033.09	749,751,095.43
39201	Барилга, байгууламж, орон сууц	439,062,895.32	439,062,895.32
39202	Хуримтлагдсан элэгдэл	-9,846,809.28	-34,333,570.92
39203	Авто-тээврийн хэрэгсэл	213,838,770.85	295,827,987.11
39204	Хуримтлагдсан элэгдэл	-65,195,583.12	-86,805,944.16
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	173,576,149.12	149,130,149.12
39206	Хуримтлагдсан элэгдэл	-91,686,976.41	-94,525,253.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	58,697,661.33	58,697,661.33
39208	Хуримтлагдсан элэгдэл	-11,245,314.59	-18,178,067.27
39214	Бусад үндсэн хөрөнгө	8,539,959.86	46,482,834.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-3,221,719.99	-5,607,596.65
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	6,900,000.00	8,849,999.96
39301	Програм хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-50,000.04
39303	Бусад биет бус хөрөнгө	6,800,000.00	8,800,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>856,788,253.18</u></b>	<b><u>890,404,810.84</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>856,788,253.18</u></b>	<b><u>890,404,810.84</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	856,788,253.18	890,404,810.84
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	15,125,400.00	15,125,400.00
51101	Өмч: - төрийн	15,125,400.00	15,125,400.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	841,662,853.18	875,279,410.84
51210	Өмнөх үеийн үр дүн	841,662,853.18	841,662,853.18
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	33,616,557.66
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>856,788,253.18</u></b>	<b><u>890,404,810.84</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>767,940,594.99</b>	<b>490,902,152.92</b>

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>402,886,194.99</b>	<b>129,996,652.92</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	402,886,194.99	129,996,652.92
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	400,436,194.99	129,996,652.92
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,160,163.00	1,267,107.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,779,600.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	389,496,431.99	128,729,545.92
120009	Бусад орлого	2,450,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>365,054,400.00</b>	<b>360,905,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	365,054,400.00	356,905,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	359,054,400.00	356,905,500.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	6,000,000.00	00.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,000,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>437,260,676.45</b>	<b>457,285,595.26</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>437,260,676.45</b>	<b>457,285,595.26</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	394,535,562.16	416,820,475.26
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	207,097,915.71	198,670,618.00
210101	Үндсэн цалин	150,304,397.71	134,714,484.00
210102	Нэмэгдэл	51,174,318.00	58,336,934.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,619,200.00	5,619,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,502,446.00	29,722,647.00
210201	Тэтгэврийн даатгал	19,357,139.00	20,319,747.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,295,738.00	2,350,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,836,570.00	1,880,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,673.00	470,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,557,326.00	4,701,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,447,550.00	5,338,474.00
210301	Гэрэл, цахилгаан	528,173.00	313,400.00
210302	Түлш, халаалт	3,919,377.00	4,890,250.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	134,824.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,150,049.04	48,776,459.56
210401	Бичиг хэрэг	3,533,875.00	9,343,979.98
210402	Тээвэр, шатахуун	25,807,174.04	14,358,823.98
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,481,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	178,400.00	456,800.00
210408	Бараа материал акалсны зардал	00.00	23,135,855.60
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	423,500.00	300,800.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	423,500.00	300,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	00.00	1,627,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	00.00	1,127,000.00
210604	Урсгал засвар	00.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,556,100.00	2,209,000.00
210702	Дотоод албан томилолт	2,556,100.00	2,209,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	58,993,617.00	47,425,448.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	58,075,892.00	46,437,348.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	71,300.00

210803	Даатгалын үйлчилгээ	153,425.00	405,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	264,300.00	248,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	15,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	247,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>61,364,384.41</b>	<b>82,750,028.70</b>
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	61,364,384.41	82,750,028.70
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,725,114.29</b>	<b>40,465,120.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>42,725,114.29</b>	<b>40,465,120.00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,725,114.29	40,465,120.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>330,679,918.54</b>	<b>33,616,557.66</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>330,679,918.54</b>	<b>33,616,557.66</b>

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,125,400.00	00.00	841,662,853.18	856,788,253.18
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	15,125,400.00	00.00	841,662,853.18	856,788,253.18
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	33,616,557.66	33,616,557.66
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	15,125,400.00	00.00	875,279,410.84	890,404,810.84

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>378,444,163.00</b>	<b>362,172,607.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>13,389,763.00</b>	<b>1,267,107.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>13,389,763.00</b>	<b>1,267,107.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,939,763.00	1,267,107.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	9,160,163.00	1,267,107.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,779,600.00	00.00
120009	Бусад орлого	2,450,000.00	00.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>365,054,400.00</b>	<b>360,905,500.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>365,054,400.00</b>	<b>356,905,500.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	359,054,400.00	356,905,500.00
131002	Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт	6,000,000.00	00.00

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны  
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	00.00	4,000,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,000,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>378,444,163.00</b>	<b>362,172,607.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>378,444,163.00</b>	<b>362,172,607.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>335,719,048.71</b>	<b>321,707,487.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	207,527,801.71	198,670,618.00
210101	Үндсэн цалин	150,734,283.71	134,714,484.00
210102	Нэмэгдэл	51,174,318.00	58,336,934.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,619,200.00	5,619,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	28,502,446.00	29,722,647.00
210201	Тэтгэврийн даатгал	19,357,139.00	20,319,747.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,295,738.00	2,350,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,836,570.00	1,880,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	455,673.00	470,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,557,326.00	4,701,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,643,800.00	4,302,224.00
210301	Гэрэл, цахилгаан	361,600.00	313,400.00
210302	Түлш, халаалт	4,282,200.00	3,854,000.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	134,824.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	19,247,700.00	14,309,700.00
210401	Бичиг хэрэг	414,300.00	352,200.00
210402	Тээвэр, шатахуун	16,935,200.00	12,235,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,630,600.00	1,481,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	267,600.00	240,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	269,300.00	269,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	269,300.00	269,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,728,500.00	2,167,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	302,900.00	242,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,425,600.00	1,425,600.00
210604	Урсгал засвар	00.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,556,100.00	2,209,000.00
210702	Дотоод албан томилолт	2,556,100.00	2,209,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	70,585,401.00	69,532,408.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	69,667,676.00	68,544,308.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	71,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	403,425.00	405,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248,500.00	248,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,800.00	15,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	247,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	658,000.00	523,690.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	658,000.00	523,690.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>42,725,114.29</b>	<b>40,465,120.00</b>
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	42,725,114.29	40,465,120.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	42,725,114.29	40,465,120.00

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	291,591,500.00	317,707,487.00
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	291,591,500.00	317,707,487.00
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	291,591,500.00	317,707,487.00
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	235,074,000.00	198,670,618.00
210101	Үндсэн цалин	137,611,800.00	134,714,484.00
210102	Нэмэгдэл	91,843,000.00	58,336,934.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	5,619,200.00	5,619,200.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	31,734,900.00	29,722,647.00
210201	Тэтгэврийн даатгал	22,332,000.00	20,319,747.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,350,700.00	2,350,700.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,880,600.00	1,880,600.00
210204	Ажилгүйдлийн даатгал	470,100.00	470,100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,701,500.00	4,701,500.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	4,303,800.00	4,302,224.00
210301	Гэрэл, цахилгаан	313,400.00	313,400.00
210302	Түлш, халаалт	3,854,000.00	3,854,000.00
210303	Цэвэр, бохир ус	136,400.00	134,824.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	14,309,700.00	14,309,700.00
210401	Бичиг хэрэг	352,200.00	352,200.00
210402	Тээвэр, шатахуун	12,235,700.00	12,235,700.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,481,000.00	1,481,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	240,800.00	240,800.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	269,300.00	269,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	269,300.00	269,300.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	2,167,900.00	2,167,900.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	242,300.00	242,300.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,425,600.00	1,425,600.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	2,213,600.00	2,209,000.00
210702	Дотоод албан томилолт	2,213,600.00	2,209,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	991,500.00	65,532,408.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	00.00	64,544,308.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	71,300.00	71,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	405,900.00	405,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	248,500.00	248,500.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	15,800.00	15,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	250,000.00	247,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	526,800.00	523,690.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	526,800.00	523,690.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	356,905,500.00	358,172,607.00
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	356,905,500.00	356,905,500.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	356,905,500.00	356,905,500.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	1,267,107.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	1,267,107.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	18.00	25.00

620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	14.00	14.00
620003	Үйлчлэх ажилтан	03.00	07.00
620004	Гэрээт ажилтан	00.00	03.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,000,000.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,000,000.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,000,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	4,000,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,000,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	
131105	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь “Бейкер Тилли Далайван аудит” ХХК-ийн аудитор Б.Пүрэвсүрэн гүйцэтгэж, эхний шатны хяналтыг ахлах аудитор, захирал Д.Мягмарсүрэн хэрэгжүүлж, 2 болон 3-р шатны хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, Орхон аймгийн төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 19-ны өдөр №08 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Тэшиг, Хутаг-Өндөр, Сэлэнгэ сумдын нутагт оршино. Хотгор гүдгэрийн хувьд Өвөр байгалийн дундаж уулсын үргэлжлэл, ландшафтын хувьд Сибирийн хөвч тайгын өмнөд төгсгөл болох уул зүйн систем, ландшафтын бүрдлийн хувьд өвөрмөц онцлогтой нутаг юм. Байгалийн муж Сэлэнгийн савын бэсрэг уулсын мужид хамрагдана. Байгалийн бүс, бүслүүрийн хувьд ойт хээрийн бүсэд багтах уулын тайга, торлогт хөндийн ландшафт голлох цулдам өндөр уулс, хотгор, томоохон голуудын хөндий бүхий гадаргатай. Тус мужид Намнангийн нуруу, Уран тогоо-Тулга уул, Хан Жаргалант уул гэсэн газрууд нь улсын тусгай хамгаалалтад орсон байдаг.

- Зэд-Хантай-Бүтээлийн нуруу нь сум, багийн төвөөс алслагдмал, улсын хил дагуу орших дундаж уулын тайга, намаг бүхий бартаа ихтэй нутаг бөгөөд газрын ашиглалт бараг хийгдээгүй онгон дагшин газар. Харин сүүлийн жилүүдэд энэ орчны ой модыг хавтгайруулан огтлох, ойн түймэрт өртөх, хортон шавьжид идүүлснээс гадна ан амьтдыг зүй бусаар агнах явдал ихэссэнээс тэдгээрийн тоо толгой цөөрч зарим зүйл нь устах аюулд хүрч байгаа.
- Нутгийн 59.7%-ийг уулын тайгын ширэгт хөрстэй үетэн бүхий нарс-шинэс болон хусан ойгоос бүрдэх дэд тайга, 31.6%-ийг уулын тайгын цэвдэгт хөрстэй давжаа бут-ногоон хөвд бүхий шинэс-хушин ба шинэсэн ойгоос бүрдэх тайга эзэлнэ. Түүнээс гадна татмын нуга 6.6%, ойт хээр 1.3%, нугат хээр 0.8% тус тус эзэлж байна. Өөрөөр хэлбэл, нийт нутгийн 91.3%-ийг ой мод бүхий тайга, дэд тайгын экосистемийг бүрдүүлдэг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод чанарын баталгаажуулалт, статистик хариуцсан ахлах ажилтан ажилладаг хэдий ч тухайн ажилтан чиг үүргээ хэрэгжүүлснээр тодорхой үр дүн гарсан эсэх нь тодорхойгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “ дунд ” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөв 356,905.5 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 3,569.0 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 2,498.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 33,616.6 мянган төгрөгөөр буюу 3.92 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлттэй гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	137,369.2	131,803.7	(5,565.5)
Үндсэн хөрөнгө	719,419.0	758,601.1	39,182.1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>856,788.2</b>	<b>890,404.8</b>	<b>33,616.6</b>
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	856,788.2	890,404.8	33,616.6
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>856,788.2</b>	<b>890,404.8</b>	<b>33,616.6</b>

Тайлант хугацаанд төсвийн хөрөнгөөр 55,381.4 мянган төгрөгийн бараа материал худалдан авч 44,608.5 мянган төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Бараа материалын дансанд Байгаль орчин аялал жуулчлалын яамны сайдын 2020 оны 05 дугаар сарын 18-ний өдрийн А/362 тоот тушаалын дагуу ариун цэврийн байгууламж барих мөн хилийн багана тэмдэг тэмдэглэгээг байршуулах ажлын хүрээнд 22,790.1 мянган төгрөгөөр нэмэгдсэн. Мөн аудитын зөвлөмжөөр бусад хангамж материалаас тусгай зориулалтад 4,580.0 төгрөгийн материалыг шилжүүлж бүртгэсэн.

Үндсэн хөрөнгийн бүртгэлд нийт 129 нэр төрлийн 998,101.5 мянган төгрөгийн хөрөнгө бүртгэлтэй байна. Байгаль орчин аялал жуулчлалын сайдын 2021 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн А/283 тоот тушаалын дагуу УАЗ Фургон маркийн автомашин, хийлдэг моторт завийг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн Хамгаалалтын захиргааны даргын 2021 оны 12 дугаар сарын 10 өдрийн А/22 тоот тушаалаар орлогот авч бүртгэлд тусгасан. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2021 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 589 дүгээр тогтоолын дагуу байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн шийдвэрийг үндэслэн 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/23 тоот тушаалаар 24,446.0 мянган төгрөгийн хөрөнгийг бүртгэлээс хассан.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 890,404.8 мянган төгрөг болж 33,616.6 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны санхүүгийн үр дүнгийн тайлангаарх нийт орлого 490,902.1 мянган төгрөг буюу өмнөх оноос 277,038.4 мянган төгрөгөөр буурсан буюу 63,9 хувиар, нийт зардал 457,285.6 мянган төгрөг буюу өмнөх оноос 20,024.9 мянган төгрөгөөр буюу 4,6 хувиар өссөн байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг мянган төгрөгөөр, нийт зарлагыг 371,538.8 мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 13,649.2 мянган төгрөгөөр бууруулан 357,889.6 мянган төгрөгөөр баталсан байна. Тайланд онд тодотгол оруулан 356,905.5 мянган төгрөг болгон баталсан.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэхээр 356,905.5 мянган төгрөгийг улсын төсвөөс, нэмэлт санхүүжилтээр 4,000.0 мянган төгрөг, 1,267.1 мянган төгрөг үндсэн үйл ажиллагааны орлогоос, 128,729.5 мянган төгрөгийг үнэ төлбөргүй хүлээн авсан, урсгал үйл ажиллагаанд 450,437.0 мянган төгрөгийг зарцуулж, 40,465.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 450,437.0 мянган төгрөг буюу нийт орлогоос 91.7 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшууллын 36,403.4 мянган төгрөг, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 2,012.2 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 32.5 мянган төгрөг, дотоод албан томилолтоос зардлыг 744.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгөөс 4,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилт авсан. Үүнээс бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж 4,000.0 мянган төгрөг зарцуулсан.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудитын хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Булган аймаг дахь Зэд хантай бүтээлийн нурууны дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны нь 2021 онд нийт 356,905.5 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 2 мэдээллийг мэдээлэх хугацаа болоогүй байна.

#### **3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн.

#### **3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

Өмнө жилийн аудитаар түүвэрт орж алдаа зөрчил илрээгүй болно.

#### **3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардал, урсгал засварын зардлын төлөвлөлт, гүйцэтгэл анхаарал татахаар бөгөөд бусад чухал асуудал байхгүй байна.

## **4. Аудитын илрүүлэлт**

Аудитаар нийт 4,617.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,580.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулсан, 37.0 мянган төгрөгийн алдаа зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

## **4.1 Залруулсан алдаа**

### **1.1. Илрүүлэлт:**

4000.0 мянган төгрөгийн зорь, 580.0 мянган төгрөгийн хөрөнгийг хангамжийн материалын дансанд бүртгэсэн байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 11 сарын 27-ны өдрийн 388 дугаар тушаалын 1 хавсралтын нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу болон 3 хавсралтын дагуу бүртгэлээ хөтөлж хэвших УСНББОУС-ын дагуу хөрөнгийн шинж чанартай хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэх.

## **4.2 Акт**

Тайлант онд акт байхгүй болно.

## **4.3 Албан шаардлага**

Тайлант онд албан шаардлага байхгүй.

## **4.4 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

### ***1. Зардлын данстай холбоотой асуудал***

#### **1.2. Илрүүлэлт:**

3 ажилтны НДШ-ийг тооцохдоо хувиа буруу тооцож 25.9 мянган төгрөгийг дутуу 11.1 мянган төгрөгийг илүү тооцсон байна. Энэ нь "Нийгмийн даатгалын тухай" хуулийн 17.1.1-т "хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх" гэсэн заалтын дагуу нийгмийн даатгалын тайланг үнэн зөв тооцож тайлагнах.

#### **1.3. Өгсөн зөвлөмж:**

Хууль, тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлэн ажиллах

### ***2. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал***

#### **2.1. Илрүүлэлт:**

Санхүүгийн тайлангийн баримтуудыг байнга болон түр хадгалах баримт бичгийг тус тусад нь ангилж үдээгүй байна. Энэ нь Архивын тухай хуулийн 45 дугаар зүйл. Албан хэрэг бүрдүүлэхдээ байнга болон түр хадгалах баримт бичгийг тус тусад нь ангилж, хөтлөх хэрэг бүрдүүлэх, хөтлөх хэргийн дотор баримт бичгийг он, сар, өдөр, дугаар, ач холбогдол, агуулга, сэдэв, уялдаа холбоог нь харгалзан дараалж бүртгэх, нэг асуудал, сэдэвт холбогдох баримт бичгийг хянан шийдвэрлэсэн дарааллын дагуу төрөлжүүлэх зарчмыг баримтлах зэрэг шаардлагуудын дагуу баримтаа бүртгэх.

#### **2.2. Өгсөн зөвлөмж:**

Санхүүгийн баримтыг хадгалах хугацаагаар нь тус тусад нь үдэх хэрэгтэй.

### ***3. Зардлын данстай холбоотой асуудал***

#### **3.1. Илрүүлэлт:**

Байгаль орчны хамгаалагч 14 ажилтны ажилласан хугацааны ээлжийн амралтыг бодож олгодоггүй байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай хуулийн 99.1. Ажилтанд ажлын жил бүр ээлжийн амралт олгож биеэр эдлүүлнэ. Ажлын зайлшгүй шаардлагаар ээлжийн амралтаа биеэр эдэлж чадаагүй ажилтанд олгох мөнгөн урамшууллын хэмжээг энэ

хуулийн 110.2-т заасан хэмжээнээс нэмэгдүүлж олгох асуудлыг хамтын гэрээгээр, хамтын гэрээгүй бол ажилтантай тохиролцон олгоно.

**Өгсөн зөвлөмж:**

Ажилтны ажилласан хугацааны ээлжийн амралтыг бодож олгож байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/


Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Зэд хантай бүтээлийн нуруу	4	4,617.0	1	4,580.0	-	-	-	-	3	37.0
Нийт дүн		4	4,617.0	1	4,580.0	-	-	-	-	3	37.0

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

**БЭЛТГЭСЭН:**

“БЕЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ” ХХК-ИЙН ОРХОН АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН

АУДИТОР:



Б.ПҮРЭВСҮРЭН

**ХЯНАСАН:**

ЧАНАРЫН ХЯНАЛТЫН МЕНЕЖЕР, ЗАХИРАЛ :



Д.МЯГМАРСҮРЭН

**АНХАН ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

АУДИТЫН МЕНЕЖЕР:




Ж.ЭНХЦООДОЛ

**ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:**

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Д.АНХБАЯР

